



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР НИЙЦЛИЙН АУДИТЫН АЛБА



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ГАДААДААС АЖИЛЛАХ ХҮЧ АВЧ АЖИЛЛУУЛАХТАЙ
ХОЛБООТОЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ”-Д
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДОА-2020/06-НА

Чойбалсан хот 2020 он



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер В.Цэнгэлмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батжаргал
Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn
Аудитор М.Ухаанбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



Товчилсон үгийн тайлбар.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4
БҮЛЭГ 1. ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ АЖ, АХУЙ НЭГЖҮҮД ГАДААДААС АЖИЛЛАХ ХҮЧ ОРУУЛЖ ИРЭХДЭЭ ХХҮГ-ИЙН САНАЛЫГ ХАРГАЛЗАН ҮЗЭХГҮЙ, ХУУЛЬ, ТОГТООМЖИД ЗААСАН ХУВЬ ХЭМЖЭЭГ ХЭТРҮҮЛЭН АЖИЛЛАХ ХҮЧ ГАДААДААС ОРУУЛЖ ИРСЭН БАЙНА.....	5-12
1.1 Зарим аж ахуй нэгжүүд гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулах шаардлага, хэрэгцээний тухай аймгийн ХХҮГ-аас санал аваагүй, хамтран ажиллах байгуулаагүй байна.	5-8
1.2 Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд гадаадын иргэн ажиллуулахдаа хууль, тогтоомжид заасан хувь хэмжээг баримтлан ажиллаагүй байна.....	8-11
1.3 Гадаадаас авч ажиллуулж буй ажиллах хүчний ажлын байрны төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн байна.	11-12
БҮЛЭГ 2. ХЯНАЛТ ТАВИХ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН АЖЛЫН УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	12-14
2.1 Эрх бүхий байгууллагууд хяналтаа бүрэн хэрэгжүүлээгүй байна.....	12-14
2.2 Хяналтын байгууллагуудаас өгсөн зөвлөмжийг хангалттай биелүүлж ажиллаагүй байна.....	14
ДҮГНЭЛТ:.....	15-16
ЗӨВЛӨМЖ:.....	15-16



Товчилсон үгийн тайлбар

НА	Нийцлийн аудит
НАГ	Нийцлийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ДОА	Дорнод аймаг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НГ	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирэх гадаадын иргэн
В	Ажил хэргийн шугамаар ирэх гадаадын иргэн
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХҮГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
ГИХГ	Гадаадын иргэн харьяатын газар



**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх**

Аудитын зорилт

**Аудитын хамарсан
хүрээ**

**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх
мэдэгдэл**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2019 оны А/100 дугаар тушаалаар батлагдсан “Аудитын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Гадаадаас ажиллах хүч авч ажиллуулахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг аймгийн ИТХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд:

- Гадаадын хөрөнгө оруулалттай аж, ахуй нэгжүүд гадаадаас ажиллах хүч авч ажиллуулахтай холбоотой хууль, тогтоомжийг мөрдөн ажиллаж байгаа эсэх
- Эрх бүхий байгууллагууд хяналтаа бүрэн хэрэгжүүлж байгаа эсэх.

Аудитад аймгийн ЗДТГ, ГИХГ-ын зүүн бүс дэх газар, аймгийн МХГ, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжүүд, Дорнод аймаг дахь аж ахуй нэгж, байгууллагууд болон тэдгээрийн 2018-2020 оны үйл ажиллагааны тайлан, мэдээ, судалгаа холбогдох баримт материалуудыг хамруулсан.

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 4000, 4100 дугаар стандарт, Төрийн аудитын Монгол Улсын стандарт MNS6817-6 болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан Нийцлийн аудитын түр журмыг баримтлан цуглуулсан баримт материалд дүн шинжилгээ хийх, газар дээр нь очиж үзэх, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тодруулга, тайлбар авах зэрэг горимуудыг ашигласан.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер В.Цэнгэлмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батжаргал, аудитор М.Ухаанбилэг, гэрээт ажилтан Б.Оюунхэрлэн, З.Шинэхүү нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын талбарын үе шатны ажлыг 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс эхлүүлж, тайланг 2020 оны 10 дугаар сарын 19-нд дуусгасан.



1. ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ АЖ, АХУЙ НЭГЖҮҮД ГАДААДААС АЖИЛЛАХ ХҮЧ ОРУУЛЖ ИРЭХДЭЭ ХХҮГ-ИЙН САНАЛЫГ ХАРГАЛЗАН ҮЗЭХГҮЙ, ХУУЛЬ, ТОГТООМЖИД ЗААСАН ХУВЬ ХЭМЖЭЭГ ХЭТРҮҮЛЭН АЖИЛЛАХ ХҮЧ ГАДААДААС ОРУУЛЖ ИРСЭН БАЙНА.

1.1 Зарим аж ахуй нэгжүүд гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулах шаардлага, хэрэгцээний тухай аймгийн ХХҮГ-аас санал аваагүй, хамтран ажиллах байгуулаагүй байна.

Дорнод аймгийн хэмжээнд 2018-2020 онд нийт 15 аж ахуйн нэгж байгууллага гадаадаас ажиллах хүч авч ажиллуулсан байна. Аж ахуй нэгж, байгууллагууд нь гадаадаас ажиллах хүч авахдаа хууль, тогтоомжид заасан шалгууруудыг хангасан байх шаардлагатай.

1. Ажиллах хүч гадаадад гаргах, ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт “Байгууллага нь энэ хуулийн 8.1-д заасан зөвшөөрлийг авахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ”, 8.2.8 дахь заалтад “тухайн байгууллагад гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулах шаардлага, хэрэгцээний тухай орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн албаны санал” –ыг гэсний дагуу аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас санал авахаар заасан байна. Уг заалтын хэрэгжилтийг шалгахад “Петрочайна дачин тамсаг” ХХК-ний гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоог тогтоохдоо 2018 онд аймгийн ХХҮГ-аас Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд өгсөн саналаас 642 хүнээр илүү, 2019 онд ХХҮГ-аас санал аваагүй, “Нью нимон Майнинг” ХХК-д 2019 онд мөн санал аваагүй байхад ЗГ-ын тогтоол гарч гадаадаас авах ажиллах хүчний тоог тогтоосон байна.

Орон нутгийн ажиллах хүчний нөхцөл боломжийг харгалзан үзэлгүйгээр ЗГ-ын тогтоол гаргаж гадаадаас ажиллах хүч авах зөвшөөрлийг олгож байгаа нь тухайн орон нутгийн шаардлага хэрэгцээг бүрэн судлахгүй байгааг харуулж байна.

2. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт “Монгол Улсад хувийн хэргээр болон энэ хуулийн 32.2-т заасан оршин суугч гадаадын иргэн 14 хоногийн дотор сумын Засаг даргын Тамгын газарт, эсхүл хорооны Засаг даргад хаягийн бүртгэл хийлгэнэ” гэж заасан байна. Аж ахуй нэгжүүд нь ажиллах хүч оруулж ирэх зөвшөөрөл авахдаа сумын ЗДТГ болон багийн Засаг даргаас тодорхойлолт авч гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлж байгаа хэдий ч орж ирсэн тохиолдолд бүртгүүлэх тухай дээрх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

3. Монгол улсад хөдөлмөр эрхэлж байгаа гадаад иргэд нь НГ ангиллын визтэй байх шаардлагатай бөгөөд Гадаадын иргэний харьяатын Зүүн бүс дэх газраас авсан нийт НГ ангиллаар орж ирсэн гадаад иргэдийн мэдээллийг аж ахуй нэгжүүдэд хөдөлмөр эрхэлж байгаа гадаад иргэдийн мэдээлэлтэй тулган үзэхэд визний ангилал зөрчсөн зөрчил илрээгүй.

Харин “Шинь шинь” ХХК-ийн гадаад ажиллагсдын нийгмийн даатгал төлөлтийн мэдээлэл нь Гадаадын иргэний харьяатын Зүүн бүс дэх газраас авсан гадаад иргэдийн мэдээллээс 1 иргэнээр дутуу байна. Тухайн иргэн нь Гадаадын иргэний харьяатын Зүүн бүс дэх газарт МУ-д хөдөлмөр эрхлэх НГ ангиллаар бүртгэлтэй, “Шинь шинь” ХХК-ний гадаад ажилтнуудын цалингийн жагсаалтад байгаа тул уг асуудлыг Нийгмийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хуулийн хүрээнд шийдвэрлүүлэхээр аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст шилжүүлсэн.




“ХХЕМ” ХХК-д “В” ангиллаар 2020 оны 1 сард орж ирсэн нэг хятад иргэн “ковид” 19 цар тахлын улмаас одоог хүртэл түр оршин суух зөвшөөрөл аваагүй, нутаг буцаагүй байна. Шалтгааныг тодруулахад “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.14 дэх хэсэгт “Хөл хорио, хөдөлгөөний хязгаарлалт тогтоосны улмаас Монгол улсаас гарах боломжгүй болсон нь холбогдох баримтаар тогтоогдсон гадаадын иргэн, харьяалалгүй хүний Монгол улсын визийн болон тус улсад оршин суух зөвшөөрлийн хугацааг тухайн нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгах, хугацаа хэтрүүлсний төлбөр, торгуулиас чөлөөлөх асуудлыг шийдвэрлэнэ.” гэсэн заалтыг үндэслэн тул визний хугацааг сар бүр сунгасан байна.

4. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн /цаашид “байгууллага” гэх/ нь шинжлэх ухаан, боловсрол, үйлдвэрлэлийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, шинэ үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, тоног төхөөрөмж угсрах, засварлах, төсөл хэрэгжүүлэх зорилгоор мэргэжлийн өндөр ур чадвар шаардах ажил, мэргэжлээр гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээг гадаадын хуулийн этгээдтэй байгуулж болно.” гэж заасан.

Дорнод аймгийн хэмжээнд ажиллах хүчний визээр орж ирсэн гадаад ажилтнууд нь дээрх хуулийн заалтад нийцэж байгаа эсэхийг үзэхэд:

- “Шинь шинь” ХХК нь 2019 онд нийт 92 гадаад иргэн ажиллуулсны 14.1 хувь нь орлогч дарга, 8.7 хувь нь хэлтсийн дарга нар эзэлж бусад мэргэжлүүд 1.1-ээс 7.6 хувийн хооронд эзэлж байна. 2020 онд нийт 86 гадаадын иргэн ажиллуулснаас инженер 8.1 хувь, техникч 9.3 хувь, хөвүүлэн баяжуулагч 9.3 хувийг тус тус эзэлж дарга, орлогч дарга нарын орон тоо 8.3 хувиар буурч дээр дурдсан нарийн мэргэжилтнүүдийн эзлэх хувь өссөн байна.
- “Тун Гуан Майнз Констракшн Монгол” ХХК нь 2019 онд нийт 37 гадаад ажилтан ажиллуулсны 14.0 хувийг цооног өрөмдөгч, 9.0 хувийг уул уурхайн инженер зэрэг нарийн мэргэжлүүд эзэлж байна.
- “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн 2020 онд оруулж ирэхээр ХХҮГ-аас дэмжлэг хүссэн хятад мэргэжилтнүүдийн жагсаалтад өндөр ур чадвар шаардаж буй нь нотлогдохгүй, дотоодод бэлтгэгддэг дараах мэргэжлүүд байна.

График 1






Эдгээр мэргэжлийн ажилтнуудыг орон нутгаас хангах боломжтой бөгөөд Дорнод аймаг дахь Политехник коллежийг “Газрын тосны оператор”, “Газрын тосны техникч” мэргэжлээр 2018 онд 21, 2019 онд 26, 2020 онд 13, нийт 60 суралцагч төгссөн байна.

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг графикаар харуулбал:

График 2



Графикаас харахад мэргэжлээрээ ажил, хөдөлмөр эрхлээгүй төгсөгчид 53.3 хувь буюу дийлэнхийг эзэлж байна.

Политехник коллежийн төгсөгчдийн ажил эрхлэлтийг судалгаагаар харуулбал:

Хүснэгт1

Анги	2018 он				2019 он				2020 он			
	Төгссөн	Петрочайна Дачин тамсаг ХХК-д	Бусад салбарт ажиллаж буй	Ажилгүй	Төгссөн	Петрочайна Дачин тамсаг ХХК-д	Бусад салбарт ажиллаж буй	Ажилгүй	Төгссөн	Петрочайна Дачин тамсаг ХХК-д	Бусад салбарт ажиллаж буй	Ажилгүй
Газрын тосны оператор	21	3	1	17	13	1	7	5	13	1	5	7
Газрын тосны техникч	Энэ онд элсэлт аваагүй				13	2	8	3	Энэ онд элсэлт аваагүй			
Нийт	21	3	1	17	26	3	15	8	13	1	5	7
Эзлэх хувь	100	14.3	4.8	81.0	100	11.5	57.7	30.8	100	7.7	38.5	53.8

Мөн Дорнод их сургуулийн газрын тосны инженерийн хөтөлбөр нь 2 удаагийн төгсөлт хийсэн бөгөөд нийт 27 оюутан төгссөн байна. Үүнээс 15 төгсөгч буюу 55.5 хувь нь “Петрочайна дачин тамсаг” ХХК-ий 19, 21 дүгээр талбайд мэргэжлээрээ ажиллаж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/74 дугаартай тушаалын 1.2-т “Өндөр ур чадвар, нарийн мэргэжил шаардсан ажлын байранд ажиллаж байгаа гадаадын мэргэжилтнүүдийг дагалдуулан сургаж Монгол залуусыг ажлын байраар



хангах, мөн мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагаар мэргэжилтэй ажилтнуудыг бэлтгэн ажлын байраар хангах арга хэмжээг зохион байгуулж уул уурхай, зам тээвэр, барилгын салбарт ажиллуулах гадаадын ажиллах хүчний тоог 2018 онд 30 хувиар, 2019 онд 20 хувиар бууруулах зорилтыг хэрэгжүүлж ажиллах;” гэж заасан байна.

Уг тушаалын дагуу Дорнод аймаг дахь Политехник коллеж нь уул уурхайн чиглэлээр сурч байгаа суралцагсдыг дадлага хийлгэх, ажлын байраар хангуулах саналыг “Шинь шинь” ХХК, “Петрочайна дачин тамсаг” ХХК-иудад удаа дараа тавьж, гэрээ байгуулахаар хүргүүлсэн ч тодорхой хариу өгөөгүй байгаа бөгөөд гэрээ байгуулж дадлага хийлгэх талаар хамтарч ажиллаагүй байна.

Төгсөгчдийг ажлын байраар хангах, суралцагчдыг үйлдвэрлэлийн дадлага хийлгэх боломж нөхцөлөөр хангуулах асуудалд дэмжлэг хүсэж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Газрын тосны хэрэг эрхлэх газар, аймгийн Засаг даргад 2018, 2019 онуудад албан бичиг хүргүүлсэн ч асуудалд ахиц гараагүй хэвээр үргэлжилж газрын тосны чиглэлээр сурч төгссөн мэргэжилтнүүд хангалттай хэмжээнд ажлын байртай болж чадахгүй байна.

Үүнд гадаадаас авч ажиллуулах ажиллах хүчний тоог тогтоохдоо мэргэжлийн өндөр ур чадвар шаардсан гэсэн шалгуурт таарсан Монгол улсад бэлтгэгддэггүй мэргэжилтэн эсэхийг хянахгүй байгаа нь нөлөөлж байна.

1.2 Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд гадаадын иргэн ажиллуулахдаа хууль, тогтоомжид заасан хувь хэмжээг баримтлан ажиллаагүй байна.

Гадаадаас ажиллах хүч авах харилцаа нь “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хууль, “Ашигт малтмалын тухай” хууль, Засгийн газрын тогтоолуудаар зохицуулагдаж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4¹, 7 дугаар зүйлийн 7.3² дахь заалтуудыг үндэслэн жил бүр аж ахуй нэгж, байгууллагын нийт ажиллагчдын тоонд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг үйл ажиллагааны чиглэлээр тогтоож Засгийн газраар батлуулж байна.

Мөн дээрх хуулийн 7.3, 9.5 дахь заалтуудыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас гадаадаас авах ажиллах хүчний тооны хязгаарыг аж ахуйн нэгж байгууллагуудаар нь тогтоож байна.

“Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн 9.2, 9.3-т аж ахуйн нэгж байгууллагууд нь гадаад иргэнийг ажлын байраар хангаж орлого олох ажил үйлчилгээ эрхлүүлсэн тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин, нийт ажиллагсдын тоонд эзлэх гадаад ажиллагсдын хувь хэмжээг хэтрүүлсэн тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг тус тус төлөхөөр заасан байна.

¹ эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын нийт ажиллагчдын тоо, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамааруулан нийт ажиллагчдын тоонд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг жил бүр тогтоож, Засгийн газраар батлуулах;

² Улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, барилга, байгууламж барих, гамшгийн хор уршгийг арилгахад шаардагдах ажиллах хүчийг дотоодоос хангах бололцоогүй нөхцөлд Засгийн газрын шийдвэрийг үндэслэн гадаадаас ажиллах хүч авч болно.



Дорнод аймагт 2018-2020 онд 15 аж ахуйн нэгжүүд гадаадаас ажиллах хүч авч ажиллуулсан байна. Ажиллах хүчний харьцааг Засгийн газрын тогтоолд заасан хувь хэмжээгээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 2

д/д	Аж ахуй нэгжийн нэрс	ЗГ-ын 2017 оны 317 дугаар тогтоол		ЗГ-ын 2018 оны 377 дугаар тогтоол		ЗГ-ын 2019 оны 420 дугаар тогтоол		Үйл ажиллагааны чиглэл
		Харьцаа хувиар		Харьцаа хувиар		Харьцаа хувиар		
		Монгол	Гадаад	Монгол	Гадаад	Монгол	Гадаад	
1	Петрочайна дачин тамсаг ХХК	50	50	70	30	70	30	Газрын тос, байгалийн хийн олборлолт
2	Шинь Шинь ХХК	65	35	90	10	90	10	Ашигт малтмал ашиглах, олборлох
3	Шанлун ХХК	75	25	90	10	90	10	Ашигт малтмал ашиглах, олборлох
4	Икс Икс И Эм ХХК	70	30	70	30	70	30	Цахилгаан, хий, уур, агааржуулалт
5	Тун Гуан Майнз Констракшин Монгол ХХК	75	25	90	10	90	10	Ашигт малтмал ашиглах, олборлох
6	Степ голд ХХК	75	25	90	10	90	10	Алтны хайгуул, олборлолт
7	Шинь-Интернэшнль ХХК	75	25	75	25	75	25	Тээвэр, авто машин
8	Зэст-Өндөр ХХК	75	25	90	10	90	10	Уул уурай
9	Спек ХХК	75	25	90	10	90	10	Уул уурай
10	Дорнын алтан тос ХХК	80	20	80	20	80	20	Газар тариалан
11	Нью Нимон Майнинг ХХК	75	25	90	10	90	10	Уул уурай
12	Про-Ариум ХХК	75	25	75	25	75	25	Алтны хайгуул, олборлолт
13	Ундран бэхжих ХХК	90	10	80	20	80	20	Авто машины засвар
14	Эйч Кэй Би Интернэшнль ХХК	70	30	70	30	70	30	Газрын тос байгалийн хий, хайгуул
15	Эко Майнинг Технологи ХХК	70	30	70	30	70	30	Газрын тос байгалийн хий, хайгуул

Эдгээр аж ахуй нэгжүүд гадаадаас ажилтан авч ажиллуулахдаа ЗГ-ын тогтоолд заасан оруулахыг зөвшөөрсөн тооны хязгаар болон дээрх хувь хэмжээг баримтлан ажилласан эсэхийг үзэхэд оруулахыг зөвшөөрсөн тооноос давсан зөрчил илрээгүй бөгөөд харин дараах аж ахуй нэгжүүд хууль, тогтоомжид заасан хэмжээнээс илүү гадаад ажилтан авч ажиллуулсан байна. Үүнд:

1. Гадаадын хөрөнгө оруулалттай, уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг “Тун Гуан Майнз Констракшин Монгол” ХХК 2019 онд хуульд заасан хувь хэмжээнээс 57 гадаадын иргэн илүү авч ажиллуулсан байна. Ажлын байрны нөхөн төлбөрт 145,9 сая төгрөг төсөвт төлөхөөс Дашбалбар сумын төсвийн орлогод 72,9 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Үлдэгдэл 72,9 сая төгрөгийг төлөөгүйд төлбөрийн акт тогтоосон.



2. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 473 дугаар тогтоолоор “Шинь Шинь” ХХК-ний 91 гадаад ажилтны 2020 онд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгасан байна.

Дашбалбар сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг “Шинь Шинь” ХХК-ний Улааны уурхай дээр очиж нөхцөл байдалтай танилцахад гадаадын 50 ажилчин ажиллаж байсан бөгөөд бусад гадаад ажилтнууд нь Цагаан сарын баяртай холбоотой нэгдүгээр сард Монгол Улсын хилээр гараад “ковид-19” цар тахлаас шалтгаалан буцаж ирээгүй байна. Эдгээр ажилтнуудын ажлын байрыг хэвээр хадгалан цалинг бүтэн ажилласнаар тооцож Монгол улсад үйл ажиллагаа эрхэлж олсон орлогоос олгосон байна.

Эдгээр ажилтнуудыг оруулан тооцоход Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч нь Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх бөгөөд тухайн хуулийн этгээдэд ажиллагсдын 10-аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно.” гэсэн заалтыг зөрчин 2020 онд сар бүрийн өссөн дүнгээр нийт 137 гадаадын ажилтныг илүү авч ажиллуулсан байна.

Хуульд заасан хувь хэмжээнээс илүү авч ажиллуулсан гадаад ажилтны ажлын байрны төлбөрт Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гадаадын иргэдийг энэ хуулийн 43.1-д зааснаас илүү хэмжээгээр авч ажиллуулсан тохиолдолд ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө.” гэсэн заалтын дагуу 237,9 сая төгрөгийг төлөөгүйд төлбөрийн акт тогтоосон.

3. Дорнод аймгийн Халхгол, Матад суманд газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулдаг гадаадын хөрөнгө оруулалттай “Петрочайна дачин тамсаг” ХХК нь 2019 онд Засгийн газрын 2018 оны 377 дугаар тогтоолд заасан газрын тос, байгалийн хийн олборлолтын салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагын нийт ажиллагсдын тоонд гадаадын ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг мөрдөж ажиллаагүй байна.

Тогтоосон хувь хэмжээнээс илүү тооны гадаад ажилчин авч ажиллуулсан тохиолдолд “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр тухайн орон нутгийн төсөвт төлөхөөр заасан байна.

“Петрочайна дачин тамсаг” ХХК нь 2019 онд сар бүрийн өссөн дүнгээр нийт 1661 ажилтныг тогтоосон хувь хэмжээнээс илүү авч ажиллуулсан ч ажлын байрны төлбөрт ногдох 5315,2 сая төгрөгийг төсөвт төлөөгүй байна.

“Петрочайна дачин тамсаг” ХХК-д 2019 онд Засгийн газрын тогтоосон хувь хэмжээнээс илүү авч ажиллуулсан гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг төлөөгүй асуудлыг танилцуулахад дараах мэдээллийг ирүүлсэн.Үүнд:

- Гадаадаас ажиллах хүч оруулж ирэхдээ “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн 9.2 “Ажлын байрны төлбөрийн хэмжээ нь 1 сард гадаадын иргэн бүрд Монгол Улсын Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.” гэсэн заалтын дагуу төлбөр төлсөн бүртгэл,



- Засгийн газрын 2018 оны 398, 2019 оны 118 дугаар тогтоолуудад заасан тоогоор ажиллах хүч оруулж ирсэн тухай тайлбар.

Албан бичгээр ирүүлсэн уг хариу тайлбар нь илэрсэн зөрчилд хамаарахгүй байгаа тул аудитын явцад тус компанийн хүний нөөцийн ажилтнаас тодруулга авахад “Засгийн газрын тогтоолуудад заасан ажиллах хүчний тоонд багтаан ажиллах хүч оруулж ирдэг. Харин Засгийн газраас аж ахуйн нэгж байгууллагын нийт ажиллагсдын тоонд гадаадын ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоосон тогтоолыг мөрдөж ажилладаггүй, манай компанид хамаарахгүй” гэсэн тайлбарыг өгсөн.

“Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн 7.3, 9.5 дахь заалтуудыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 398, 2019 оны 118 дугаар тогтоолуудад гадаадын хөрөнгө оруулалттай газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулдаг “Петрочайна дачин тамсаг” ХХК-ний 2019 онд гадаадаас авах ажиллах хүчний тоог тогтоосон байна. Энэ нь Монгол улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгож буй тус компанийн гадаадаас авах ажиллагсдын тооны хязгаар юм.

Харин дээрх хуулийн 4.1.4, 7.3 дахь заалтуудыг үндэслэн тогтоосон Засгийн газрын 2018 оны 377 тогтоолд 2019 онд газрын тос, байгалийн хийн олборлолтын салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагын нийт ажиллагсдын тоонд гадаадын ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг зааж өгсөн байна.

“Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн 9.2, 9.3-т гадаад иргэнийг ажлын байраар хангаж орлого олох ажил үйлчилгээ эрхлүүлсэн тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин, нийт ажиллагсдын тоонд эзлэх гадаад ажиллагсдын хувь хэмжээг хэтрүүлсэн тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг тус тус төлөхөөр заасан байна.

Иймд “Петрочайна дачин тамсаг” ХХК -ний Засгийн газрын 2018 оны 377 дугаар тогтоолд заасан 2019 онд газрын тос, байгалийн хийн олборлолтын салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагын нийт ажиллагсдын тоонд гадаадын ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг мөрдөж ажиллаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд нь хууль, тогтоомжид заасан хувь хэмжээнээс илүү тооны гадаад ажилтан авч ажиллуулах, ажлын байрны нөхөн төлбөрөө төлөхгүй байх нь орон нутгийн иргэдийг ажлын байраар хангаж, ажилтай орлоготой байх боломжийг бууруулж байна.

1.3 Гадаадаас авч ажиллуулж буй ажиллах хүчний ажлын байрны төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн байна.

Гадаадаас ажиллах хүч авч ажиллуулж байгаа аж ахуйн нэгжүүд Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 9.2 дахь хэсэгт “ажлын байрны төлбөрийн хэмжээ нь 1 сард гадаадын иргэн бүрд Монгол Улсын Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.” гэж заасны дагуу ажлын байрны төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлдэг байна.

Монгол Улсын Засгийн газрын 41 дүгээр тогтоолоор баталсан ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журмын 2.1-д” Байгууллага нь гадаадын иргэнд



Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авахдаа Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 8.1-д заасан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний эрх олгосон байгууллагад ажлын байрны төлбөрийг урьдчилан төлнө гэж заасны дагуу Дорнод аймагт үйл ажиллагаа явуулсан аж ахуй нэгжүүд 2019-2020 оны ажлын байрны төлбөрийг дараах байдлаар төлсөн байна.

Хүснэгт 6

д/д	Аж ахуйн нэгжийн нэр	2019 он /сая.төг/			2020 он /сая.төг/		
		Гадаад ажиллах хүчний тоо	Төлбөл зохих ажлын байрны төлбөр	Төлсөн ажлын байрны төлбөр	Гадаад ажиллах хүчний тоо	Төлбөл зохих ажлын байрны төлбөр	Төлсөн ажлын байрны төлбөр
1	"Петрочайна дачин тамсаг"	870	6,681,6	6,681,6	604	6,088,3	6,088,3
2	"Шинь Шинь" ХХК	98	752,6	752,6	91	917,2	917,2
3	"Шанлун" ХХК	6	46,0	46,0	5	50,4	50,4
4	"Икс Икс И Эм" ХХК	11	84,4	84,4	5	50,4	50,4
5	"Тунгуанмайнз" ХХК	39	299,5	299,5	37	372,9	372,9
6	"Степ голд" ХХК	1	7,6	7,6	2	20,1	20,1
7	"Шинэ-Интернэшнль" ХХК	2	15,3	15,3	2	15,3	15,3
8	Зэст өндөр ХХК	2	15,3	15,3	-	-	-
9	Спек ХХК	9	69,1	69,1	-	-	-
10	Дорнын алтан тос ХХК	5	19,2	19,2	-	-	-
11	Нью Нимон Майнинг ХХК	11	84,4	84,4	-	-	-
12	Про-Ариум	5	38,4	38,4	-	-	-
13	"Ундрэнбэхжих" ХХК	3	23,0	23,0	3	30,2	30,2
14	Эйч Кэй Би Интернэшнль ХХК	2	15,3	15,3	-	-	-
15	Эко Майнинг Технологи	1	7,6	7,6	-	-	-
	НИЙТ	1,065	8,160,0	8,160,0	749	7,545,1	7,545,1

Гадаадаас ажиллах хүч оруулж ирсэн аж ахуй нэгжийн тоо 2020 онд буурсан нь “ковид-19” цар тахал гарч хил хаасантай холбоотой байна. Ингэснээр 2020 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн ажлын байрны төлбөр өмнөх оноос 614,9 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй гарсан байна.

Аж ахуйн нэгж нь гадаадаас ажиллах хүчээ оруулахаасаа өмнө ажлын байрны төлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлдөг учраас ажлын байрны төлбөр төлөгдөхгүй байх эрсдэл бага байна.

2. ХЯНАЛТ ТАВИХ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН АЖЛЫН УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

2.1 Эрх бүхий байгууллагууд хяналтаа бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Гадаадаас ажиллах хүч авч ажиллуулахтай холбоотой хуулийн хэрэгжилтэд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу түүний эрх олгосон байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газар, холбогдох хууль, хяналтын байгууллага хяналт тавихаар тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасан байна.



1. Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас 2019 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын А/318 тоот тушаалын хүрээнд гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулж буй аж ахуй нэгжийн үйл ажиллагаатай танилцаж, үнэлэлт өгөх ажлыг зохион байгуулсан байна.

Тус хяналт шалгалтад дотоод, гадаадын хөрөнгө оруулалттай 24 аж ахуй нэгжийн Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл бүхий 1518 гадаад иргэний хөдөлмөрийн харилцаа, гүйцэтгэж буй ажил үүргийн хуваарь, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, баримт бичиг, аж ахуй нэгжийн үйл ажиллагаатай танилцаж нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт хийсэн байна. Үүнд:

- “Петрочайна Дачин тамсаг” ХХК, “Дорнын хөгжил транспорт” ХХК, “Нью Нимон Майнинг” ХХК, “Ган ширээс” ХХК-иуд нь ажиллах хүч оруулж ирэхдээ гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулах шаардлага, хэрэгцээний тухай орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн албаны саналыг аваагүй.
- “Петрочайна Дачин тамсаг” ХХК, “Дорнын хөгжил транспорт” ХХК, “Шанлун” ХХК, “Ган ширээс” ХХК, “Ундран бэхжих” ХХК-иуд нь орон сууц болон ажиллах орчин муу, эрүүл ахуйн шаардлага хангахгүй, хөдөлмөрийн харилцаа муу, ажилчидтай хөдөлмөрийн гэрээ хийгдээгүй, цалинг хуульд заасан хугацаанд олгодоггүй.
- Зарим компаниудад Монгол, гадаад ажилтны хувь хэмжээ алдагдсан, гэрээ хийгдээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газраас гадаадаас ажиллах хүчин авч ажиллуулахтай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

3. Сумдын ЗДТГ-ын дарга, багийн дарга нартай холбоотой Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт “Монгол Улсад хувийн хэргээр болон энэ хуулийн 32.2-т заасан оршин суугч гадаадын иргэн 14 хоногийн дотор сумын Засаг даргын Тамгын газарт, эсхүл хорооны Засаг даргад хаягийн бүртгэл хийлгэнэ”. Мөн уг хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэгт “Сум, хорооны Засаг дарга гадаадын иргэний асуудлаар дараах эрх, үүрэгтэй.” 9.7.1 дэх заалтад “нутаг дэвсгэртээ оршин суугаа гадаадын иргэний хаягийн бүртгэл хөтлөх;” гэсэн үүргийн хэрэгжилтийг шалгахад түр оршин суугаа гадаад иргэдийн бүртгэлийг хөтлөөгүй байна.

Тухайлбал Дашбалбар суманд “Шинь шинь” ХХК, “Тун гуан майнз Констракшн Монгол” ХХК, Халхгол суманд “Петрочайна Дачин тамсаг ХХК/21/, Матад суманд Петрочайна Дачин тамсаг ХХК /19/, “Спек” ХХК, Чойбалсан суманд “Дорнын алтан тос” ХХК, “Нью Нимон Майнинг” ХХК, “Шанлун” ХХК, Баяндун суманд “Про-Ариум” ХХК, Цагаан-Овоо суманд “Степ голд” ХХК-иудын гадаад иргэдийн бүртгэлийг холбогдох ЗДТГ болон багууд хөтлөөгүй байна.

Сум, багийн Засаг дарга нар нь түр оршин суух зөвшөөрөлд шаардагдах тодорхойлолтыг гаргадаг ч орж ирсэн эсэхэд хяналт тавихгүй байгаа нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.7.1³ дэх заалтад дурдсан үүргээ хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой байна.

³ нутаг дэвсгэртээ оршин суугаа гадаадын иргэний хаягийн бүртгэл хөтлөх;



Тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа гадаад иргэдтэй холбоотой мэдээлэл, судалгаа нутгийн захиргааны байгууллагад байхгүй байгаа нь Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих эрх бүхий төрийн байгууллагуудын шаардлагатай мэдээллийг олж авах байдалд сөргөөр нөлөөлж байна.

3. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2018 оны 01/15 тоот тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн хэрэгжилтэд аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2018 онд Дорнод аймгийн нутаг дэвсгэрт гадаадын иргэдийг ажиллуулж буй аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийсэн байна.

Хяналт шалгалтад “Петрочайна дачин тамсаг” ХХК, “Шинэ интернэшнл” ХХК, “Шинь шинь” ХХК, “Тун гуан майнз констракшн” ХХК, “ХХЕМ” ХХК-иуд, ерөнхий боловсролын “Шинэ хөгжил” цогцолбор сургууль, хэрлэн сумын 5,12 дугаар цэцэрлэг хамрагдсан байна. Тус хяналт шалгалтаар гадаад ажилтнуудын ажлын байрны төлбөртэй холбоотой зөрчил илрээгүй байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2019 онд “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтаар “Шинь Шинь” ХХК-тай холбоотой хуульд заасан ажиллах хүчний харьцаанаас илүү тоогоор гадаад ажилтан авч ажиллуулсны ажлын байрны төлбөрийг төлөөгүй зөрчлийг илрүүлж, төлбөрийн акт тогтоож төсөвт төвлөрүүлсэн байна.

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас “Гадаадаас ажиллах хүч авч ажиллуулахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт”-д 2016, 2020 онуудад аудит хийхэд дээрх зөрчлүүд давтагдан гарсаар байна.

Иймд гадаадаас ажиллах хүч авч ажиллуулахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг орон нутгийн түвшинд төрийн байгууллагуудыг төлөөллийг оролцуулан зохион байгуулж, ажлын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

2.2 Хяналтын байгууллагуудаас өгсөн зөвлөмжийг хангалттай биелүүлж ажиллаагүй байна.

Дорнод аймаг дахь хяналтын байгууллагуудаас Дорнод аймагт уул уурхай, газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдэд гарсан зөрчилтэй нь холбогдуулан үүрэг даалгавар, зөвлөмж, албан шаардлага өгч ажилласан байна. Уул уурхай, газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүд өгсөн үүрэг даалгавар, зөвлөмж, албан шаардлагыг хангалттай биелүүлж ажиллаагүй байна.



ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Зарим аж ахуй нэгжүүд гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулах шаардлага, хэрэгцээний тухай аймгийн ХХҮГ-аас санал аваагүй, хамтран ажиллах гэрээ байгуулаагүй байна.
2. Сумдын ЗДТГ, багийн Засаг дарга нар гадаад иргэдийн түр оршин суугаа бүртгэлийг хөтлөхгүй байна.
3. Орон нутгийн ажиллах хүчний нөхцөл боломжийг харгалзан үзэхгүй, орон нутгийн иргэдийн ажиллах боломжтой ажлын байранд гадаад иргэдийг ажиллуулж байна.
4. Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд гадаадын иргэн ажиллуулахдаа хууль, тогтоомжид заасан хувь хэмжээг баримтлан ажиллаагүй байна.
5. Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд хууль, тогтоомжид заасан хувь хэмжээнээс илүү авч ажиллуулсан гадаад ажилчдын ажлын байрны төлбөрийг төсөвт төлөөгүй байна.
6. Хяналт тавих эрх бүхий байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд:

1. Гадаадаас ажиллах хүч авч ажиллуулахтай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг орон нутгийн түвшинд төрийн байгууллагуудыг төлөөллийг оролцуулан зохион байгуулж, ажлын уялдаа холбоог сайжруулах.

Сумын Засаг дарга нарт:

2. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7.1 дэх заалтын дагуу нутаг дэвсгэртээ оршин суугаа гадаадын иргэдийн бүртгэл хөтөлж ажиллах.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Мөнхгэрэлд:

3. Гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулах шаардлага, хэрэгцээний тухай санал аваагүй, хамтран ажиллах гэрээ байгуулаагүй аж ахуй нэгжүүдийн асуудлыг холбогдох дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

Аймгийн МХГ-ын дарга Д.Мөнхтуяад:

4. Гадаадаас ажиллах хүч авч ажиллуулахтай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтын ажлын үр дүнг сайжруулах.



Аудитаар 5626,0 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, холбогдох албан тушаалтнуудад 4 зөвлөмж өгч, ҮАГ-т аудитаар илэрсэн асуудлыг шийдвэрлүүлэх талаар 1 саналыг хүргүүллээ.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2021 оны 10 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



ДОРНОД АЙМАГ, ХЭРЛЭН СУМ, 7-Р БАГ АЙМГИЙН ЗДТГ-ЫН 2 ДУГААР БАЙР
УТАС: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-МЭЙЛ: DORNOD@AUDIT.GOV.MN , ВЕБ САЙТ: WWW.AUDIT.MN